



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/48

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 28 дугаар зүйлийн 28.7.2, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1, аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/75 дугаар захирамж, Шивээговь сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 06 дугаар “Сумын 2024 оны төсөв батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Улс орон даяар өвөлжилт хүндэрч, зудын эрсдэлт нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд Сэг зэм устгалын цэг байгуулсугай.

2. Сэг зэм устгалын ажилд зарцуулагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

2. Сэг зэм устгалын цэг байгуулах ажилд зарцуулагдах 9,000,000 (есөн сая) төгрөгийг холбогдох хууль, журмын дагуу баримт бичгийн бүрдлийг хангаж, Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Ахлах нягтлан бодогч (Л.Туяа)-д зөвшөөрсүгэй.

3. Тус ажлыг чанартай зохион байгуулж, стандартын шаардлагыг мөрдлөг болгон ажиллахыг сэг зэм устгалын ажлын хэсэгт, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА



Сумын Засаг даргын 2024 оны 04-р сарын 04-ны өдрийн 4/48 дугаар захирамжийн хавсралт

**СЭГ ЗЭМ УСТГАЛЫН АЖИЛД ЗАРЦУУЛАГДАХ
ЗАРДЛЫН ТӨСӨВ**

№	Зардлын нэр	Нэгж үнэ	Тоо хэмжээ	Нийт дүн
1	Ажил гүйцэтгэх гэрээгээр сэг зэмийн нүх ухах	1	8,000,000	8,000,000
2	Сэг зэм устгалын цэгийн хашаажуулалт	125,000	8	1,000,000
Нийт дүн				9,000,000